



**ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ
КОРПОРЭЙШН ХК**

ХУВЬЦААНЫ ТОВЧ СУДАЛГАА

Энэхүү судалгааг “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК-ийн 2025 оны 3-р улирлын санхүүгийн тайлан болон зах зээл дээрх нээлттэй мэдээлэлд үндэслэн бэлтгэсэн болно.

ТОВЧ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Хүснэгт №1

Хувьцааны мэдээлэл

Тикер:	MSE:	ERDN
	TSX:	ERD
	OTCQB:	ERDCF
Салбар	Уул уурхай	
Нийт гаргасан хувьцаа ширхэг	61,874,216	
Эргэлтэнд гаргасан хувьцаа	61,874,216	

Хүснэгт №2

Ханшийн мэдээлэл

Огноо	2026.02.10	
Одоогийн ханш	20,260.0 ₮	8.15 CAD
52 долоо хоног-Дээд	25,320.0	
52 долоо хоног-Доод	9,222.0	
Зах зээлийн үнэлгээ	1,253,571,616,160.0	
Арилжааны дундаж хэмжээ ₮, өдрөөр, МХБ	144,738,841.65	

Хүснэгт №3

Харьцаа үзүүлэлтүүд

EPS-Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	-496.64 ₮	-0.19 CAD
P/E-Үнэ/Ашгийн харьцаа	-	
P/B-Үнэ/Дансны үнийн харьцаа	9.3	
P/S-Үнэ /Орлогын харьцаа	-	
Ногдол ашиг %	-	

*1 CAD = 2613.89 ₮, Монголбанк


Хүснэгт №4

Ашигт ажиллагаа

Нийт хөрөнгийн өгөөж	-20.3%
Эздийн өмчийн өгөөж	-20.6%
Цэвэр ашгийн маржин	Борлуулалт эхлээгүй учир орлого олж эхлээгүй байгаа

Зураг №1

Ханшийн хөдөлгөөн



ТОВЧ СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Бид компанийн бүтэц зохион байгуулалт, сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан болон бусад холбогдох мэдээлэлд үндэслэн энэхүү товч судалгааг хөрөнгө оруулагчид, харилцагчдадаа хүргэж байна. Тус компанийн хувьд олон нийтэд танилцуулсан хамгийн сүүлийн санхүүгийн тайлан 2025 оны 09-р сарын 30-ны өдрөөр байгаа бөгөөд тус улирлын байдлаар компанид борлуулалтын орлого бүртгэгдээгүй байгаа болохыг анхаарна уу.

Цаашид хувьцааны үнэлгээнд нөлөөлж болохуйц 3 хүчин зүйлсийг товч дурдвал:

1. Алтны үнийн өсөлт

Алтны үнэ дэлхийн геополитикийн хурцадмал нөхцөл байдал, худалдааны тариф, Төв банкны нөөц бүрдүүлэлт зэрэг хүчин зүйлсээс үүдэн өнгөрсөн 2025 онд 65.4%-иар өссөн нь энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын ашигт ажиллагаанд эергээр нөлөөлж байна.

2. Борлуулалтын төсөөлөл

Тус компани нь одоогоор алтны "Баянхөндий" орд дээр түшиглэн энэ оны 3-р улиралд боловсруулах үйлдвэрээ ашиглалтад оруулж, үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд анхны бүтээгдэхүүнээ (алт) гаргаснаар орлого олж эхэлсэн байна. Энэ нь цаг хугацааны хувьд алтны үнэ анх төсөөлсөн үнээс давсан үе таарч байгаа нь борлуулалтын орлого цаашид нэмэгдэх хүлээлт үүсгэж байна.

3. Бусад ордын хүдэржилт, агуулгын хэмжээ

Тус компанийн эзэмшил бүхий хэд хэдэн ордын хүдэржилт, агуулгын хэмжээ нэмэгдсээр байгаа тухай албан мэдээллүүд гарсаар байна. (Зуунмод молибден-зэсийн төсөл)

КОМПАНИЙН ТУХАЙ

Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн ХК (ERDN) нь 2000 оны 06-р сарын 27-нд Канад Улсад үүсгэн байгуулагдсан бөгөөд тус компанийн Гүйцэтгэх захирлаар Акерли Петер ажиллаж байна.

1. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Компанийн хувь эзэмшил хамгийн сүүлийн мэдээллээр буюу 2026 оны 2-р сарын 22-нд компанийн албан ёсны цахим хуудсанд нийтэлсэн тайланд дурдсанаар дараах байдалтай байн. Үүнд:

Хүснэгт №5. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

№	Овог нэр	Эзэмшиж буй %
1	Эрик Спротт	23.0%
2	Жижиг хувьцаа эзэмшигчид	31.0%
3	Байгууллагын ХО-лагчид	38.0%
4	Монгол хувьцаа эзэмшигчид*	4.0%
5	Удирдлага, захирлууд	4.0%

Эх сурвалж: erdene.com, *МУ-д 7000 гаруй хувьцаа эзэмшигчидтэй

2. Компанийн хувь оролцоо бүхий компани

Тус компани нь стратегийн түншлэлийн хүрээнд Монгол Улсад бүртгэлтэй Эрдэнэ Монгол ХХК-ийг Монголын томоохон уул уурхайн компани болох Монголиан Майнинг Корпорэйшн ХК-тай хамтран 50:50 хувиар эзэмшдэг байна.

Хүснэгт №6. Хөрөнгө оруулалттай компани

№	Компанийн нэр	Хувь
1	Эрдэнэ Монгол ХХК	50.0%
2	Аниан Ресорсиз ХХК	100.0%

Эх сурвалж: erdene.com

3. Компанийн эзэмшил бүхий орд, газрууд

Тус компани нь өөрийн эзэмшил бүхий компаниудаар дамжуулан дараах орд газруудыг эзэмшдэг болно. Үүнд:

Хүснэгт №7. Эрдэнэ Монгол ХХК-ийн эзэмшил бүхий ордуудын жагсаалт

№	Ордын нэр	Эрдэсийн нэр	Зөвшөөрлийн төрөл
1	Баянхөндий	Алт	Ашиглалтын лиценз
2	Хар морь	Алт	
3	Алтан нар	Алт-Полиметалл	
4	Улаан	Алт	Хайгуулын лиценз

Эх сурвалж: erdene.com

Мөн тус компани нь Хөндий эрдэсийн дүүрэгт олборлох алтны эхний 400,000 унцаас давсан дүнд "Net Smelter Return" 5%-

ийн нөөцийн татвар авах эрхийг эзэмшдэг байна.

Хүснэгт №8. Аниан Ресорсиз ХХК-ийн эзэмшил бүхий ордуудын жагсаалт

№	Ордын нэр	Эрдэсийн нэр	Зөвшөөрлийн төрөл
1	Зуунмод	Зэс-молибден	Ашиглалтын лиценз
2	Хувь хар	Зэс	

Эх сурвалж: erdene.com

Түүнчлэн 2025 оны 2-р улиралд Оюу толгой ордоос баруун урагш 10км-т байрлах "Тэрэг уул" зэс-алтны төслийн 80 хүртэлх хувийг эзэмших "Опцион гэрээ"-г байгуулсан байна.

4. Баянхөндий ордын нөөц, ТЭЗҮ товч мэдээлэл

Компанийн "Баянхөндий алт"-ны төсөлд харьяалагдаж буй "Баянхөндий", "Хар морин дэл" ордуудын нөөцийн болон ТЭЗҮ-д туссан мэдээллийг товч байдлаар дараах хүгнэстэд харуулав. Үүнд:

Хүснэгт №9. Ордын нөөц, унцаар

№	Ордын нэр	Эрдэсийн нэр	Гарц, г/т	Нөөц, мян.унц
1	Баянхөндий	Алт	3.8	464.9
		Мөнгө	1.8	220.5
2	Хар морь	Алт	7.0	48.8

Эх сурвалж: erdene.com

Тус төслийн хүрээнд компани нийт 476.0 мянган унц алт, 121.1 мянган унц мөнгийг олборлож, тус бүрийг нь 1,797.3 ам.доллар, 23.6 ам.доллороор тус тус худалдан борлуулахаар тооцсон байна.

Хүснэгт №10. Төслийн санхүүгийн тооцоолол

№	Мэдээлэл	Хэмжих нэгж	Тоо, дүн
0	Борлуулах алт (99.85%)	унц	476,001.0
0	Борлуулах мөнгө (99.85%)	унц	121,097.0
1	Төслийн цэвэр борлуулалт	сая USD	856.8
2	Ү/а-ны зардал	сая USD	351.6
3	АМНАТ	сая USD	51.5
4	Үл хөдлөхийн татвар	сая USD	2.9
5	Ү/А-ны ашиг	сая USD	450.8
6	Анхны ХО-ын зардал	сая USD	100.4
7	ХО-ын засвар үйлчилгээ	сая USD	3.7
8	Байгаль орчин, төсөл хаах	сая USD	6.8
9	Бусад	сая USD	2.0
10	Мөнгөн гүйлгээ, тат.өмнө	сая USD	341.9
11	ААНОАТ	сая USD	97.7
12	Мөнгөн гүйлгээ, тат.дар	сая USD	244.2

Эх сурвалж: erdene.com

ТОВЧ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Төслийн хөрөнгө оруулалтын тооцоололд хорогдуулах хүүг 5.0%-иар авч, цэвэр өнөөгийн үнэ цэнийг татварын дараах байдлаар 170.1 сая ам.доллороор тооцсон бөгөөд анхны хөрөнгө оруулалтаа нөхөх хугацааг 2.4 жил байхаар тусгасан байна.

Хүснэгт №11. Төслийн хөрөнгө оруулалтын тооцоолол

№	Татварын өмнөх	Татварын дараа	Хэмжих нэгж
NPV	245.0	170.1	Сая \$
Discount rate	5.0	5.0	%
IRR	44.3	35.3	%
Анхны ХО нөхөх хугацаа	2.0	2.4	жил

Эх сурвалж: erdene.com

КОМПАНИЙН БОРЛУУЛАЛТ

Тус компанийн “Баянхөндий” алтны ордын олборлолт 2025 оны 09-р сард эхэлсэн ба тус оны 4-р улиралд хийгдсэн борлуулалтын мэдээг 2026 оны 02-р сарын 20-нд өөрийн цахим хуудсанд нийтэлсэн байна.

Хүснэгт №12. Борлуулалтын дүн мэдээ, 2025/Q4

№	Эрдсийн төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ \$	Нийт дүн
1	Алт, унц	7,434	4,153	30,873,402
2	Мөнгө, унц	2,634	53	139,602
	Нийт дүн \$			31,013,004

Эх сурвалж: erdene.com

Дунджаар 2 г/т алтны агуулга бүхий 144,845 тонн хүдэр боловсруулсан ба тус боловсруулах үйлдвэр нь өдөрт 1,950 тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай байна.

Тус компани стратегийн хувьд энэхүү алтны ордыг нэн түрүүнд ашиглалтад оруулан, олборлолтоо эхлүүлэх, түүний дараа бусад ордуудыг хөгжүүлэх ажлуудыг шат дараатай эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Тус компанийн 2025 оны жилийн эцсийн тайлан хараахан гараагүй байгаа бөгөөд 2025 оны 3-р улирлын тайлан мэдээ гарсантай холбогдуулан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг нэгтгэн харуулж байна.

Тайлант хугацаанд орлого бүртгэгдээгүй тул орлогын тайлан алдагдалтай байгаа бөгөөд эх үүсвэрийн хувьд 2024 оноос эхлэн эздийн

өмчийн санхүүжилт давамгайлсан дүр зурагтай байна.

Хувьцааны ширхэгийг МХБ-д бүртгүүлсэн хамгийн сүүлийн тоогоор авсан болно.

Хүснэгт №13. Санхүүгийн тайлан, мян. CAD

Санхүүгийн тайлан	2023.IX	2024.IX	2025.IX
Эргэлтийн хөрөнгө	30,142.23	2,683.79	6,169.59
Эргэлтийн бус хөрөнгө	64,101.39	53,633.81	49,708.27
Нийт хөрөнгө	94,243.61	56,317.60	55,877.86
Нийт хөрөнгийн өөрчлөлт, %-иар	97.2%	-40.2%	-0.8%
Богино хугацаат өр төлбөр	45,756.18	440.09	1,483.03
Урт хугацаат өр төлбөр	-	-	70.39
Нийт өр төлбөр	45,756.18	440.09	1,553.41
Нийт өр төлбөрийн өөрчлөлт, %-иар	6074.4%	-99.0%	253.0%
Эздийн өмч	48,487.43	55,877.51	54,324.45
Эздийн өмчийн өөрчлөлт, %-иар	3.1%	15.2%	-2.8%

Орлогын тайлан	2023.IX	2024.IX	2025.IX
Нийт ашиг (алдагдал)	(4,814.75)	(5,622.36)	(5,091.25)
Цэвэр ашиг (алдагдал)	(4,846.62)	(6,234.77)	(11,372.02)
Цэвэр ашиг (алдагдал)-ын өөрчлөлт %-иар	-1.3%	28.6%	82.4%

Мөнгөн гүйлгээний тайлан	2023.IX	2024.IX	2025.IX
Ү/а-ны мөнгөн урсгал	(7,326.91)	(2,735.30)	(3,606.79)
ХО-ын мөнгөн урсгал	(20,258.98)	(178.57)	(681.38)
Санхүүжилтийн МУ	33,696.30	1,086.50	2,369.13
Валютын ханшийн өөрчлөлт	97.87	20.77	(5.72)
Цэвэр МУ	20,862.10	(1,806.60)	(1,924.77)
Бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл	28,283.70	2,543.00	5,373.63
Хувьцааны ширхэг	61,321.06	61,321.06	61,321.06
EPS	(0.08)	(0.10)	(0.19)

Ашигт ажиллагаа	2023.IX	2024.IX	2025.IX
Эздийн өмчийн өгөөж	-10.1%	-11.9%	-20.6%
Нийт хөрөнгийн өгөөж	-6.8%	-8.3%	-20.3%
Цэвэр ашгийн ахиуц	-	-	-

Эх сурвалж: Toronto Stock Exchange

САЛБАРЫН СУДАЛГАА

1. Алтны зах зээлийн судалгаа – Товч

2025 оны турш алт нийт 53 удаа бүх цаг үеийн дээд ханшаа шинэчлэн тогтоосон бөгөөд жилийн эцсийн дүнгээр 65.4%-ийн өсөлтийг үзүүлж, 4,339.65 ам.доллар/унц хүрсэн байна.

2025 онд нийт эрэлт анх удаа 5000 тн-ыг давсан бөгөөд үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар буюу алтны ETF-үүдийн худалдаж авсан хэмжээ 801 тоннд хүрсэн нь түүхэн дээд үзүүлэлт болоод байна. Төв банкуудын худалдан авалт өндөр хэвээр

ТОВЧ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

байгаа ч өнгөрсөн жилээс 21%-иар буурч, 863.3 тоннд хүрсэн байна.

Дэлхийн томоохон банк санхүүгийн байгууллагуудаас 2026 оны эцэст алтны ханш хэрхэх тухай таамаглалуудыг шинэчлэн гаргасан бөгөөд эдгээрээс J.P.Morgan (2026.02.02) 6,300 ам.доллар, Goldman Sachs 5,400 (2026.01.22) ам.доллар-т хүрэх таамаглал танилцуулсан байна.

ТОВЧ ДҮГНЭЛТ

Энэхүү товч судалгааг хөрөнгө оруулагч, харилцагчдад тухайн компанийн ерөнхий мэдээллийг нэг дор харах, цаашид ханшинд нөлөөлж болохуйц хүчин зүйлс болон салбарын хандлагыг харуулах зорилгоор бэлтгэсэн болно.

Тус компанийн хувьд тайлант хугацаанд борлуулалт бүртгэгдээгүй буюу алдагдалтай ажиллаж байгаа учир хөрөнгө оруулагчдын нийтлэг ашигладаг үнэ/ашгийн харьцааг тооцох боломжгүй байгаа бол үнэ/дансны үнийн харьцаа 9.2-тай байна.

Энэхүү судалгаа нь дэлгэрэнгүй судалгаа биш учир аливаа хэлбэрийн үнэлгээ, тэр дундаа хорогдуулсан мөнгөн урсгалын арга ашиглаагүй болно.

ХОЛБОО БАРИХ ХАЯГ

Б.Баасандорж

Ахлах санхүүгийн шинжээч

Өлзий & Ко Капитал ҮЦК ХХК

Цахим шуудан: info@ucc.mn;

baasandorj@ucc.mn;

Цахим хаяг: www.ucc.mn;

Утас: 976-7777-6377

Гар утас: 8085-6377

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр,

25 давхар, 2506 тоот

МЭДЭГДЭЛ

Энэхүү товч судалгааны ажлыг “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК-ийн 2025 оны 09-р сарын 30 өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, 2026 оны 1-р сард нийтэлсэн үйл ажиллагааны танилцуулга болон шинжээчийн шаардлагатай гэж үзсэн бусад олон нийтэд

нээлттэй мэдээлэлд үндэслэн “зөвхөн мэдээллийн зорилгоор” боловсруулсан бөгөөд зах зээлийн болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр өөрчлөгдөж болохыг анхаарна уу.

Тиймээс хөрөнгө оруулагч та хөрөнгө оруулалтын шийдвэрээ **бие даан** сайтар нягталж гаргах нь зүйтэй бөгөөд энэхүү мэдээллээс үүдсэн аливаа эрсдэлийг Өлзий & Ко капитал ҮЦК ХХК болон судлаач ямар нэгэн байдлаар хариуцахгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Цахим шуудан: researchandmarketing@ucc.mn;

Цахим хаяг: www.ucc.mn;

Утас: 976-7777-6377

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр,
25 давхар, 2506 тоот